



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар А/150

Есөнбулаг сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлаас баталсан "Алсын хараа-2050", "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 2.2.2.1 дэх заалтад тусгасан "Мэргэжлийн ур чадвартай ажилтан, мэргэжилтнийг ахлах ангиас нь эхлэн бэлтгэх", "Цахим үндэстэн" баримтлах чиглэл 2022-2027, Цахимаар нэн тэргүүнд бодлогын зөвлөмж, "Цахим аймаг" бодлогын зөвлөмж, аймгийн Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд болон аймгийн Засаг дарга нарын хамтран ажиллах гэрээ, Цахим-Алтай хөтөлбөрийн ухаалаг иргэн зорилтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын мэдээллийн технологийн мэдлэгийг сайжруулах, инновац хийх чадвартай бүтээлч иргэдийг бэлтгэх, мэдээллийн технологийн салбарын хүний нөөцийн хөгжлийг дэмжих, улс, тив дэлхийд амжилтын эзэд болох гарааг эхлүүлэх зорилгоор "ХУРДАН КАП-2026" тэмцээнийг зохион байгуулах, удирдамжийг хавсралтаар баталсугай.

2."Боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөр"-ийн хүрээнд аймгийн Засаг даргын нэрэмжит "ХУРДАН КАП-2026" харилцаа холбоо, мэдээлэл технологийн тэмцээнийг зохион байгуулахад хөрөнгө зарцуулсугай.

3.Тус тэмцээнийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэн хамтарч ажиллахыг Боловсролын газар, Биеийн тамир спортын газар, ерөнхий боловсролын сургуулийн удирдлагуудад тус тус үүрэг болгосугай.

4.Тус тэмцээний үйл ажиллагааны зардал 5,085,000 (таван сая наян таван мянга) төгрөгийг хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын дарга (Д.Эрдэнэжаргал)-д даалгасугай.

5.Захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймгийн Цахим шилжилт, үйлчилгээний хэлтсийн дарга (Б.Оюунцэцэг)-д, хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

D:zahiramjZax ZD 2025

8000010342